



ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН XV ХУРАЛДААНЫ

ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 09

Зуунмод

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.17, 35.1.14, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.5, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
- 2.Батлагдсан журмыг аймгийн хэмжээнд мэдээлж, мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.
- 3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Ч.Жавзанпагма)-д үүрэг болгосугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд үүрэг болгосугай.
- 5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ЖАМБАЛСҮРЭН

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ,
ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ,
УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

"Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаал баталсан "Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага" бусад хууль тогтоомжид нийцүүлэн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2014 оны 16 дугаар тогтоолоор баталсан "Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, санхүүжүүлэх журам"-ыг шинэчлэн боловсруулж батлуулан, мөрдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдолыг багасгах, урьдчилан сэргийлэх үүднээс иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, тээвэрлэн устгах, төвлөрсөн хогийн цэг талбайд ландфилл аргаар газарт булшлахтай холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, өрх айл, байнга болон түр оршин суугч иргэн бүгд дагаж мөрдөнө.

1.3 Журмыг хэрэгжилтэнд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга түүний тамгын газар, багийн иргэдийн хурал, багийн Засаг дарга, төрийн албан хаагчид хяналт тавьж, мөрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

Хоёр. Хог хаягдлын тухай нэр томъёоны зарим тодорхойлолт

2.1 Энэ журамд хэрэглэгдэж буй нэр томъёог Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан утгаар ойлгоно.

2.2 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий этгээд гэж хог хаягдал цуглуулах тээвэрлэх зөвшөөрөлтэй, иргэн аж ахуйн нэгжийг хэлнэ.

Гурав. Тавигдах ерөнхий шаардлага болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

3.1.1. Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасны дагуу зохих шатны Засаг даргатай гэрээ байгуулсан, Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлсэн бүртгэлийн дугаар бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

3.1.2. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл бүхий, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлсэн бүртгэлийн дугаар бүхий аж ахуй нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

3.1.3. Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

3.1.4. Хог хаягдлыг үүсгэгч болон Эрх бүхий этгээд нь зөвхөн энгийн хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах ба аюултай хог хаягдал энэ тавигдах шаардлагад хамаарахгүй.

3.1.5. Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуй нэгж байгууллага нь тайлан мэдээг сар бүрийн 25-ны дотор харьяа сумын байгаль орчны хяналтын байцаагч болон холбогдох албан тушаалтанд тогтмол хүргүүлэх.

3.2. Хог хаягдлыг ангилахад тавигдах ерөнхий шаардлага

3.2.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь болон үйл ажиллагааны явцад дор дурдсан төрлөөр заавал ангилна.

3.2.2. "Дахивар" буюу дахин ашиглагдах хог хаягдал:

- а. Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр бичгийн цаас, төрөл бүрийн бодлын картон, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- б. Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, хүнсний зориулалттай хуванцар, ариутгагч бодисын хуванцар сав гэх мэт/
- в. Шил /хүнсний болон ундааны бүх төрлийн шилэн сав/
- г. Модон эдлэлийн хаягдал
- е. 0.025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол
- ж. Хөнгөн цагаан, зэс, гууль, бусад метал тэдгээрээр хийсэн эд зүйлс

3.2.3. "Бусад хог" хаягдалд:

- а. Биологийн болон хүнсний гаралтай хог хаягдал
- б. Барилгын гаралтай хог хаягдал
- в. Бусад төрлийн хог хаягдал

3.2.4. "Үнс"-хаягдалд:

- а. Өрхийн;
- б. Халаалтын болон нам даралтын зуухны
- в. Цахилгаан болон дулааны уахилгаан зуухны.

3.2.3. Дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч эрх бүхий этгээдийн хэрэгцээ шаардлага, тухайн орон нутгийн онцлог, шаардлагад тулгуурласан төрлөөр хог хаягдлыг ангилан ялгаж болно.

3.2.4. Иргэн аж ахуйн нэгж байгууллага нь ангилсан хог хаягдлаа зориулалтын дагуу эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.2.5. Ангилан ялгах сав нь дараах хэсгээс бүрдэнэ.

- а. Гэр хорооллын хог хаягдал ангилан хаях сав нь "Дахивар, Бусад хог, Үнс" гэсэн хэсгээс бүрдэнэ.
- б. Албан байгууллага, аж ахуй нэгж, орон сууцны хог хаягдал ангилан хаях сав нь "дахивар хог, шил, бусад хог" гэсэн хэсгээс бүрдэнэ.

3.2.6. Ангилан ялгах сав, байршуулах газарт тавигдах шаардлага

- а. Ангилан ялгах хог хаягдлын төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ бүхий байж болно.
- б. Айл өрхийн гэрт 5-10, хашаанд 80-120, байгууллагын дотор 10-40, гадна 80-150 литрийн багтаамжтай байх;
- в. Цоорч гэмтээгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар байх;
- г. Тагтай, хуванцар, метал материалаар хийгдсэн байх;
- д. Салхин доор, гэр байшин, хүнс боловсруулах, хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт байрлуулах;
- е. Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн, нягтаршуулсан, цементлэсэн, зориулалтын хавтан, дэвсгэр дэвсэх;
- ж. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай байх.
- и. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.3. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

3.3.1. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

3.3.2. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төрхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.

- а. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрмжийг сум, багийн Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.
- б. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.
- в. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцлийг бүрдүүлсэн байна.
- г. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ид тод харагдахуйц байршуулсан байна.

д. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.

е. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.

ж. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдлыг хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

3.3.3. хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;

б. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

в. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

3.3.4. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

3.3.5. Хог тээвэрлэх график, маршрутыг жил, улирал, сараар гаргаж, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан сумын Засаг даргаар батлуулна.

3.3.6. Дуудлагаар хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж болох ба энэ талаар сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тодорхой тусгана.

3.3.7. Хог тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байх, задгай тэвштэй тээврийн хэрэгсэлээр тээвэрлэх бол хог хаягдал хийсэж унахгүй байх асуудлыг шийдвэрлэсэн байна.

3.3.8. Сумын Засаг даргатай гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, байгууллага хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгалыг хууль, журам, энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол улсын стандартыг мөрдөн ажиллана.

3.3.9. Аюултай хог хаягдлыг ахуйн гаралтай хог хаягдлаас тусд нь савлан цуглуулж, тээвэрлэх бөгөөд "тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан журам"-ыг мөрдөнө.

3.4. Хог хаягдлыг сэргээх ашиглах, дахин боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага

3.4.1. Хог хаягдлыг дараах байдлаар ашигласныг сэргээн ашиглах гэж үзнэ.

а. Хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх

б. Байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, зөвшөөрсөн арга, технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, ариутгах, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд ашигтай болгож хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах

3.4.2. Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаа нь Хог хаягдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

а.Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.

б.Энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 3.4.1.б-д заасан аргаар хог хаягдлыг сэргээн ашиглахдаа эрх бүхий этгээд өөрийн үйлдвэрийн байранд, өөрийн эзэмшсэн техник технологийн дагуу хог хаягдлыг нэрэх, цэвэрлэх, сэргээх үйл ажиллагаа эрхэлж болно.

в.Хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ашигласан бүтээгдэхүүн нь хүн, мал, амьтан, ургамалд хор хөнөөлгүй байх.

г. Сэргээн ашиглах үйл ажиллагааны холбогдох зөвшөөрлийг зохих шатны Засаг даргаас авсан байна.

3.4.3. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.12-д заасныг ойлгох ба хуулийн 16, 17 дугаар зүйлд зааснаас дор дурдсан шаардлагыг хангасан байна.

а.Хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч Эрх бүхий этгээд нь түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон хог хаягдал цуглуулах эрх бүхий этгээдээр дамжуулан цуглуулж авна.

б.Хог аягдал дахин боловсруулах арга, технологи нь байгаль орчинд ээлтэй, орчин үеийн хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт технологи байна.

в.Дахин боловсруулах үйлдвэр, цехээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, ургамал, байгаль орчинд аюулгүй хүний хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

г.Хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөлтэй байна.

3.4.4.Дахин боловсруулж байгаа түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан мэдээг сумын засаг даргын тамгын газарт сар, улирал бүр албан ёсоор хүргүүлэх,

3.5. Хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

3.5.1.Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна.

а.Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий этгээд зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах;

б.Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах;

в.Биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцлөөр боловсруулж устгах;

г. Зориулалтын байгууламжид байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах;

д. Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах;

3.5.2.Хог хаягдлыг зориулалтын дагуу устгахдаа байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсын байгууллага хүлээн зөвшөөрсөн арга, техник хэрэгслээр устгана.

3.5.3. Энгийн хог хаягдлыг булшлах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.14-д заасныг ойлгор ба хуулийн 16, 17 дугаар зүйд зааснаас гадна дор дурдсан шаардлагыг хангасан байна.

а.Байгальд 5-10 жил хоргүйгээр уусч алга болох хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфил талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшилна.

б.Байгальд 10-с дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсэх хог хаягдлыг булшлахаас бусад аргаар устгана.

в.Хог хаягдлыг булшлах ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй нөхцөлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

3.5.4.Энгийн хог хаягдал булшлах төвлөрсөн цэгт тавигдах шаардлага болон зохицуулах харилцааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар"-аар зохицуулна.

3.5.5. Ландфилийн аргаар устгах хог хаягдлын талбайг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

Дөрөв. Хориглох зүйлс

4.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ил задгай газар ахуйн хог, үнс, малын гаралтай хог, барилгын болон эмнэлгийн гаралтай хаягдал хаях, шатаах,

4.2. Хүн ам төвлөрөн суурьшсан бүс, ундны эх үүсвэр, болон эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах,

4.3.Худалдаа үйлчилгээ, өргөн хэрэглээнд 0.035 мм хүртлэх зузаантай гялгар уутыг хэрэглэх,

4.4.Хог хаягдал цуглуулан тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллага нь хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулах, зориулалтын бус цэгээс бусад газар хог хаягдлыг хаях,

4.5. Албан байгууллага аж ахуй нэгж байгууллага нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулсан хогийн саванд хог хийхийг хориглоно.

Тав. Эрх, үүрэг

5.1.Аймгийн Засаг даргын эрх үүрэг:

5.1.1.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох

5.1.2.Хууль журмыг хэрэгжүүлэхэд нь сумдын засаг дарга болон иргэн, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллах

5.1.3.Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, үйл ажиллагааг зохион байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.2.Сумын Засаг даргын эрх үүрэг:

5.2.1.Энэхүү журмын 3.3.3-д заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэлтэй хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуул"-ийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах

5.2.2.Аймгийн Засаг даргын 2009 оны 453 дугаар захирамжаар баталсан нийтийн цэвэрлэгээний өдөр /сар бүрийн эхний долоо

хоногийн бямба гариг/-өөр бүх нийтийг хамарсан цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх, ард иргэдийг татан оролцуулах

5.2.3.Энэхүү журмын 3.3.3-д заасан хуваарыг батлах, хяналт тавих, хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, дахивар хогийг боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг дарж булахад шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт суулгах,

5.2.4.Хог хаягдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагаас гадна тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын хүнд даацын техник хэрэгслүүдийг хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбай багасгалт, булшлах ажилд ашиглаж болно.

5.2.5.Нутаг дэвсгэрийн хэмжээнд аж ахуй нэгж, байгууллагын хог хаягдал, цас мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох

5.2.6.Хог хаягдлын тайлан мэдээг 6, 12 дугаар сарын 20-ны дотор гарган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх, улсын нэгдсэн мэдээллийн санд оруулах;

5.2.7.Эм, эмнэлгийн байгууллага болон барилга, зам тээвэр, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан журмын дагуу тээвэрлэх, устгахыг шаардах, хяналт тавих

5.2.8.Аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн тогтоож, түр хадгалах байр, түүнийг тээвэрлэх зам маршрут гарган батлана,

5.2.9. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих;

5.2.10."Хог хаягдлыг ангилах, цуглуулан тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, урамшуулах журам"-ыг хэрэгжүүлэх, хяналт тавих

5.2.11.Энэхүү журмын 3.2.4-д заасан шаардлагын дагуу албан байгууллага, ААН, айл өрхөд ангилан ялгах хогийн савыг байршуулах ажлыг зохион байгуулах

5.2.12. Журмын 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8-дахь зүйлд заасан үйл ажиллагаанд хяналт тавих, шаардах, хамтран зохион байгуулах

5.2.13.Энэхүү журмын 3.4.3 заасан үйл ажиллагааг дэмжин ажиллах, хяналт тавих

5.3. Багийн Засаг даргын хүлээх эрх үүрэг:

5.3.1.Хог хаягдлыг эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилах, үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хог хаягдлыг бууруулах, ангилах, сэргээн ашиглах, дахин боловсруулах мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулах,

5.3.2.Баг, хороодод сайн дурын идэвхтэн ажиллуулах, хяналт тавих, дэмжин ажиллах

5.3.3.Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын тээвэрлэлтийн график, хугацаа, давтамжинд хяналт тавьж, хамтран ажиллах,

5.3.4.Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад гэр хороолол, СӨХ-тэй хамтран орон сууцны айл өрхийн иргэдийг татан оролцуулах,

5.3.5.Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үхсэн малын сэг зэмийн устгалд хяналт тавьж ажиллах.

5.3.6.Энэхүү журмын 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8 дахь зүйлд заасан арга хэмжээнд хяналт тавих, дэмжин ажиллах

5.4.Байгууллага, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг:

5.4.1.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагад батлагдсан хуваарийн дагуу хүлээлгэн өгөх,

5.4.2.Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

5.4.3.Эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг Барилга болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу ангилан, цуглуулах, тээвэрлэх, устгах

5.4.4.Стандартын шаардлага хангасан ангилан ялгах хогийн савтай байх, ангилан ялгах савыг шаардлагатай цэгт байршуулах,

5.5.Орон сууцны хорооллын айл өрхийн хүлээх үүрэг:

5.5.1.Дахин ашиглагдах боломжтой хаягдлаа ангилан ялгаж, хоёрдогч түүхий эд цуглуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэн өгөх,,

- 5.5.2.Нэгдсэн хогийн цэггүй тохиолдолд энгийн болон дахивар хог хаягдлыг хуваарийн дагуу хог тээвэрлэх машинд ачуулна,
- 5.5.3.Энгийн болон дахивар хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт хаяагүй айл өрхийг үнэн зөв баримттай мэдээллэх, шаардлага тавих
- 5.5.4.Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, орц, байрны орчны ариутгал цэвэрлэгээг тодорхой графикын дагуу тогтмолжуулах, ангилан ялгах хогийн савыг байршуулах

5.6.СӨХ-ийн хүлээх үүрэг

- 5.6.1.Харъяалагдаж буй орон сууцныхаа оршин суугчдад хог хаягдлыг ангилан ялгаж ачуулах болон ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаар мэдээлэл өгч, сургалт сурталчилгааг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулах, нийтийн цэвэрлэгээнд айл өрхийг татан оролцуулах.
- 5.6.2.Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх
- 5.6.3.Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амдрах нөхцлийг бүрдүүлж, орц, байрны орчны ариутгал цэвэрлэгээг тодорхой графикийн дагуу тогтмолжуулах

5.7 Гэр хорооллын айл өрхийн хүлээх үүрэг:

- 5.7.1.Хог хаягдлаа ангилан, зориулалтын тагтай саванд хадгалж, батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагад хүлээлгэн өгөх,
- 5.7.2.Малын өтөг бууцаа нийтийн эзэмшил газар овоолохгүй, тараахгүй байх, өөр төрлийн хогтой холилгүй хуримтлуулж хог тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах эрх бүхий иргэн болон этгээдэд шилжүүлэх, өөрсдийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн асгах тохиолдолд багийн засаг дарга, холбогдох албан тушаалтанд мэдэгдэж нэгдсэн журмын дагуу асгах
- 5.7.3.Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулахад хамтран оролцож, хашааны дотор болон гадна хэсгийн ойр орчмыг цэвэрлэж хэвших,
- 5.7.4.Хөдөөгийн айл өрх нь нутаглаж буй газрынхаа ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх

5.8.Хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах аж ахуй нэгжийн хүлээх үүрэг:

- 5.8.1.Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах хуваарийг гарган сумын Засаг даргаар батлуулах
- 5.8.2.Энэхүү журмын 3.3.5-д заасан шаардлага хангасан тээврийн хэрэгслээр хог хаягдлыг тээвэрлэх.
- 5.8.3.Иргэдийн гомдлыг бүрэн барагдуулж дуудлагаар хог ачиж тээвэрлэх, батлагдсан хуваарийн дагуу доголдолгүй ажиллах,
- 5.8.4.Энэхүү журмын 3.3.1-д заасан шаарлагыг дагуу ажилтан албан хаагчдыг сургалтанд хамруулах, хэрэгслээр хангах.
- 5.8.5.Ил задгай хог асгасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг эрх бүхий улсын байцаагч, харъяалах Засаг даргад үнэн зөв мэдээллэх, зөрчлийг арилгахад хамтран ажиллах,
- 5.8.6.Хог хаягдлын тайлан мэдээг сар бүрийн 25 дотор тайлагнах,

5.9.Идэвхтэн иргэдийн эрх үүрэг

- 5.9.1.Сумын нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй ил задгай хог хаясан, шатаасан, иргэн аж ахуйн, нэгж байгууллагыг зохих албан тушаалтанд мэдээлэх, шаардлага тавих, ил задгай талбайд хог үүсгэхгүй байхад хяналт тавих.
- 5.9.2.Хог хаягдлын сургалтын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, гарын авлага тараах материал тараах,
- 5.9.3.Нийтийг хамарсан цэвэрлэгээнд иргэдийг татан оролцуулах, хогийн ачилт тээвэрлэлтэд хяналт тавих, мэдээллээр хангах
- 5.9.4.Энэхүү журмын 6-д заасны дагуу урамшуулал авах,

5.10.Олон нийтийн байцаагчийн хүлээх үүрэг:

- 5.10.1. Хог хаягдлын тухай хууль тогтоомжоор тогтоосон захиргааны үүргийн биелэлтэд хяналт тавих,
- 5.10.2.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавьж хууль, зөрчсөн этгээдийг эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх.
- 5.10.3.Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад иргэдийг татан оролцуулахад багийн Засаг дарга, Идэвхтэн иргэдтэй хамтран ажиллах.
- 5.10.4.Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад идэвхтэй оролцсон үлгэр жишээ иргэдийг бусдад сурталчлах, хөхүүлэн дэмжих

Зургаа . Урамшуулал

- 6.1."Хог хаягдлыг ангилах, цуглуулан тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг сурталчлах, урамшуулах үйл ажиллагааг тусгай журмаар

зохицуулна.

Долоо. Хог хаягдалтай хобогдолтой үйл ажиллагаанд хяналт тавих

7.1.Хог хаягдалтай холбогдох журмын хэрэгжилтэд сумын Засаг дарга хяналт тавих,

7.2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төсөвт төвлөрсөн орлого, зарцуулалтын байдалд эрх бүхий улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана.

7.3.Иргэд, төрийн бус байгууллага хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд энэхүү журмын биелэлтэд хөндлөнгийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах талаар санал, хүсэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж болно.

7.4.Иргэн, аж ахуйн нэгж байгууллага хог хаягдалтай холбоотой санал, хүсэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж болно.

Найм. Хариуцлага хүлээлгэх

8.1.Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 43-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

____оОо____